



# "ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ" ХК

20 19 оны 07 сарын 31 өдөр

№ .....

## КОМПАНИЙН 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

Компани тайлант хугацаанд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд компанийн хэвийн үйл ажиллагаа явуулах эргэлтийн хөрөнгө, түүхий эд материалыг бэлтгэх эх үүсвэрийг бий болгохын тулд нэмэлт үнэт цаас гаргах, гадны хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр ажиллалаа.

Хувьцаа хуваах, Нэмж үнэт цаас гаргах талаар Санхүүгийн зохицуулах хорооноос гарган мөрдүүлж буй журам, зааврууд болон "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу холбогдох материалуудыг бэлтгэж ажиллав.

Биржийн бүртгэлд бүртгүүлэх бэлтгэл шатанд хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөлтэй андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэгч этгээд "Бумбат Алтай" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Түүнчлэн компанийн 2018 оны санхүүгийн тайланд "Од бүртгэл аудит" ХХК-иар аудит хийлгэн хараат бус аудиторын тайлан гаргуулсан. Өмгөөллийн "Эм Ди Эс энд ХААНЛЕКС" ХХН-тэй гэрээ байгуулан ажиллаж "Дархан гурил тэжээл" ХК-ийн Үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах шийдвэр нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх тухай хууль зүйн дүгнэлт гаргууллаа. Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох шаардлагыг ханган "Үнэт цаасны зах зээлд оролцогчдод үнэлгээний үйлчилгээ үзүүлэх" эрх бүхий хөрөнгийн үнэлгээний "АТЕН" ХХК-тай гэрээ байгуулан хамтарч ажиллан "Дархан гурил тэжээл" ХК-ийн Бизнесийн үнэлгээний тайлан гаргуулж хүргүүлсэн болно.

Хувьцаа эзэмшигчдийн өөрийн хөрөнгө, компанийн хөрөнгийн бусад эх үүсвэрүүдээс төсөвт төлөх газар болон хүн амын орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн бүрэн барагдуулсан болно.

Гурилын үйлдвэрлэлийн түүхий эд болох улаанбуудай тариалагч түнш аж ахуйнууд болон газар тариалан эрхлэгч нартай уулзан хамтын ажиллагаагаа сэргээх, үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа дэмжүүлэх талаар харилцан ашигтай хамтын ажиллагааны хувилбаруудыг харилцан солилцож ажиллаж байна.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА



Б.ТҮВШИНТӨР